



П. Дулмаа, СӨБСС-ийн ахмад багш

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ГЭР БҮЛИЙН ТӨЛӨВШИЛД ЮУГ ЧУХАЛЧЛАН ҮЗВЭЛ ЗОХИЛТОЙ ВЭ?

Abstract: Discipline is underlining factor of successful realization of the individuals and the development of the community. Discipline is used by parents to teach their children about expectations, guidelines and principles. Children need to be given regular discipline to be taught right from wrong and to be maintained safe. Child discipline can involve rewards and punishments to teach self-control, increase desirable behaviors and decrease undesirable behaviors. While the purpose of child discipline is to develop and entrench desirable social habits in children, the ultimate goal is to foster sound judgment and morals so the child develops and maintains self-discipline throughout the rest of his/her life. Well disciplined ones can become a valuable member of a society. Parents and other caregivers, with their values, beliefs, education, behaviors, customs and communications, play important role in child development.

Түлхүүр үг: Бага нас, хүүхэд төрснөөс эхлэн сургуульд орох хүртэлх (0-6) нас, Сахилга бат. Үүрэг хариуцлага, дүрэм журам, цэгцтэй хуваарилалт (discipline), Сэтгэл зүрх, сэтгэл зүтгэл.

Үндэслэл

Бага насны хүүхдийн цогц хөгжлийн шаардлагыг хангахад гэр бүл, насанд хүрэгчдийн туслалцаа дэмжлэг чухал болох нь судалгаагаар нотлогдсон асуудал юм. Хүнээр хүн хийх уламжлалт аргын суурь үндэслэл нь эцэг эх, асран хамгаалагчид бодит үйлээрээ үлгэрлэн амьдралд тохиолдох аливаа асуудлыг зөв шийдэх арга ухаанд сургаж, өвлүүлж ирсэн уламжлал юм. Ийм учраас эцэг эх, гэр бүлийн гишүүн бүр дүрэм журам үүрэг хариуцлага, эмх цэгцтэй, хувийн зохион байгуулалттай, сахилга баттай, харилцааны зөв хандлага төлөвшилтэй

байж үр хүүхдээ үлгэрлэн хүмүүжүүлэх үүрэг хариуцлага хүлээдэг.

Бага насны хүүхдийн олон талт хөгжил төлөвшлийн чухал бүрэлдэхүүн бол сахилга бат, хариуцлага, харилцааны зөв хандлага төлөвшилтэй байх асуудал юм. Учир нь зөв Монгол хүүхэд төлөвшүүлэх үйл ажиллагаа сахилга бат, хариуцлагаас эхлэх шаардлагатай гэж үзэх хүн олон байгаа юм. Улс орон хөгжихийн үндэс суурь нь сахилга бат учраас бага насны хүүхдийн сахилга бат, хариуцлагын төлөвшил илүү үнэ цэнэтэй тэргүүн зэргийн шаардлагатай тулгамдсан асуудал болж байгаа юм.

Ямар хүүхэд вэ? гэж ярилцахдаа харилцааны зөв хандлага, бие даах байдал, эрүүл мэнд, сахилга бат, дэг журмын төлөвшлийг суурь хэмжүүр болгож хэвшвэл ямар вэ? гэсэн асуудлаар олон түмэнтэй санал солилцох зорилгоор энэхүү нийтлэлийг толилуулж байна.

Бага насны хүүхдийн гэр бүлийн төлөвшилд юуг чухалчлан авч үзвэл зохилтой вэ? гэсэн асуудал эцэг эх, асран хамгаалагч, насанд хүрэгчдийн дунд тавигддаг. Асуудалд хүмүүс олон хэлбэрийн хариулт ирүүлдэг.

Олон эцэг эх, хүүхдээ төлөв түвшин хүн болгох, цэвэрч нямбай, ажилсаг, нөхөрсөг, тусархаг, авьяаслаг, хүнлэг, хичээнгүй зориг тэсвэртэй, бүтээлч гэх мэт өөр өөрсдийн хүсэл, бодол мөрөөдлийг илэрхийлдэг. Төр нийгмийн зүгээс ч өсвөр бага насны хүүхдийн сайн сайхны төлөө бодлого шийдвэр гаргаж ажилладаг. Төрөөс боловсролын талаар баримтлах (2016-2026) бодлогын шинэчлэлд бага насны хүүхдийн (0-6) нас боловсролын зорилтыг тодорхойлохдоо хүний насан туршдаа хөгжих хөгжлийн суурь үе гэж үзсэн. (Гантөмөр Л, 2016 Өдрийн сонин)

Бага насны тухайд яаж ойлгох вэ?

Бага насны хүүхдийн цогц хөгжлийн талаар баримталж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх (СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ, Бага насны хүүхдийн хөгжил) стандарт (2011) - ын агуулгад хүүхэд төрснөөс эхлэн сургуульд орох хүртэлх (0-6) насыг “Бага нас” гэж үзэх болсон. Энэхүү стандартад бага насны хүүхдийн цогц хөгжлийн шаардлагыг хангахад гэр бүл, насанд хүрэгчдийн туслалцаа дэмжлэгт тавих наад захын шаардлагыг тусгасан байгаа.

Стандартад эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдийн анхны багшийн хувьд хүүхдээ эрүүл өсгөж, бойжуулж хөгжүүлэхдээ Монгол Улсад мөрдөж байгаа эрхзүйн хууль, дүрэмд зохицуулж гүйцэтгэх үүрэгтэй гэж заасан байна. Бидний сургаж хөгжүүлж байгаа үйл ажиллагааг уламжлалт арга ухаан гэж үздэг.

Гэр бүлийн нөхцөлд хүүхдийг хайрлаж, хамгаалж өсгөхдөө тэднийг байнга ажиглаж, бодох сэтгэх чадвар, тунгаан бодох, эргэцүүлэн дүгнэх зэрэг танин мэдэхүйн сэтгэлгээний аргыг ашигладаг. Ийнхүү үр хүүхдээ хүн болгож ирсэн уламжлал дээр бид суурилан ажилладаг билээ. Хүнээр хүн хийх уламжлалт аргын суурь нь эцэг эхчүүд бодит үйлээрээ үлгэрлэн, амьдралд тохиолдох аливаа асуудлыг зөв шийдэх арга ухаанд сургадаг туршлагыг өвлөн эзэмшүүлэх нь бидний үүрэг юм.

Бага насны хүүхэд гэр бүлийн орчинд аав ээжийнхээ ар өвөрт наалдаж өсөж торнихдоо гэр орны болон хүрээлэн буй орчин, гэрийн хэвшсэн дэг журам, гэр бүлийн гишүүдийн харилцаа зэрэг нь тэдний оюун санааны хөгжил бүрэлдэн тогтох суурь хөрс болдог. Бага насны хүүхдийн хүмүүжил, төлөвшилд эцэг эх, гэр бүлийн гишүүдийн үлгэр дууриалал, үүрэг хариуцлага аль хэр нөлөөтэй, үр дагавартай байдаг талаар эрдэмтэн судлаачид сургаал бүтээлээ бичиж үлдээсэн нь олонтоо байдгийг бид мэднэ.

Сэтгэлзүйч Выгодский Л.С тухайн нийгмийн нөхцөл болон <БАГА НАСНЫ> шинж гэдэг ойлголтыг авч үзвэл хүүхдийн хүрээлэн буй орчин, эцэг эх, асран хамгаалагчдын харилцаа нь тухайн насанд бүрэлдэн буй хөгжлийн бүрдэл шинжтэй гэжээ. Японы философч Фукузова Юкичи (япон) “он-т бус” Хүмүүнийг байгаль, нийгэмдээ зөвөөр амьдарч чадах, мөн үүрэг хариуцлагаа ухаарсан, дүрэм журмаа мөрддөг иргэн хүний төлөвшлийн суурийг бага насанд нь тавина” гэжээ.

Эрдэмтэн судлаачдын үзэл баримтлалаас харахад гэр бүл нь бага насны хүүхдийн өсөж бойжих, хөгжиж төлөвших анхдагч орчин юм гэж ойлгож болох нь. Харин гэр бүлийн нөхцөлд хүүхдийг хөгжүүлж, төлөвшүүлэх оновчтой арга үйл ажиллагааг зөв сонгоход анхаарах нь чухал.

Ярилцлагын эхэнд тавигдсан (Бага насны хүүхдийн гэр бүлийн төлөвшилд юуг чухалчилбал зохилтой вэ?) асуудалд иргэн Одсүрэн Б. (судлаач, докторант)-ийн гэр бүлийн орчинд хүүхдийн төлөвшилд сахилга бат хариуцлагыг илүү анхаарах нь зүйтэй юм гэсэн нийтлэл 2016 (Өдрийн сонин) олзуурхууштай санагдсан бөгөөд энэ санал хүнээр хүн хийх гэж, зөв монгол хүүхэд төлөвшүүлэх гэж зорьж яваа олон эцэг эх, насанд хүрэгчдийн сэтгэлд хүрч дэмжигдэнэ гэдэгт итгэлтэй байгаа.

Сахилга бат гэж юу вэ?

Энэ нь дүрэм журам, үүрэг хариуцлага, цэгцтэй хуваарилалт (discipline) гэж Одсүрэн Б. бичсэн байна. Сахилга бат бүхэл бүтэн судлагдахуун болж хөгжжээ. Хувь хүн аятайхан амьдрахаас эхлээд улс орон хөгжихийн үндэс суурь нь сахилга бат юм.

Сахилга бат гадаад дотоод хоёр хүчин зүйлээс бүрэлддэг. Дотоод сахилга бат нь хүний өсөх орчин, амьдрах хэв маягаар бүрэлддэг “сэтгэл зүтгэл” юм. Сахилга батын хүмүүжил урт хугацааны үйл явцад бүрэлдэж төлөвшдөг байна.

Ийм болохоор зарчимч, ёс зүйтэй, сахилга баттай боломжийн нэг иргэнийг өсгөхийн тулд эцэг эх, асран хамгаалагч, сургалтын байгууллагаас доод тал нь 18-20 жил уйгагүй, тасралтгүй хүмүүжүүлэх, сургах хөгжүүлэх үйл ажиллагааны үр дүнд энэ төлөвшил сууна.

Өндөр хөгжилтэй орнууд энэ үнэ цэнэтэй ажлыг удаан хугацаанд бүтээсэн байдаг. Сахилга батын тогтолцоо хэр зэрэг хөгжсөнөөс улс орны хөгжил, ёс суртахуун шууд хамаарч байгаа нь тод мэдрэгддэг. Бид Япон хүний ёс журам сайтайг, Америк хүний ажил хэрэгч байдлыг, Герман хүний цаг нарийн баримталдаг, аливаад нарийн тооцоотой ханддагийг сайн мэддэг.

Манай залуучууд шинжлэх ухаан, урлаг соёл, спортын салбарт өндөр амжилт бүтээл гаргаж дэлхийн түвшинд хүрсэн амжилт бүтээлээр өрсөлддөг, түүгээр бид бахархдаг. Харин нийт иргэдийн дунд авч үзвэл, дүрэм журам баримтлах, үүрэг хариуцлагаа ухамсарлахгүй байх, амьдралын эмх цэгцтэй

хуваарилалт, харилцааны соёл төлөвшлийн түвшингээр дээрх хэмжээнд хүрч чадахгүй байгаа нь ажиглагддаг. Энэ нь сахилга батын хүмүүжил гүйцэд төлөвшиж чадаагүй, олж авсан хүмүүжил нь хэрэглээ, дадал хэвшил болж чадаагүйн илэрхийлэл юм.

Ийм учраас иргэдийн ухамсар болон бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжиж, гэр бүлийн хүмүүжлээр тэдэнд сахилга батын төлөвшил суулгах нь цаг үеийн тулгамдсан асуудлын нэг болж байгаа юм. Нийгмийн харилцааг асар их хөнгөвчилж, соёлыг дээшлүүлж болох, хүмүүсийн харилцаа, хувь хүний зохион байгуулалт бол хамгийн чухал асуудал юм.

Хувийн сахилга баттай, боловсролтой, чадвартай, төлөвшсөн хүн бол хамгийн үнэ цэнэтэй нийгмийн баялаг юм. Бид ийм хүнийг төлөвшүүлэхийн тулд гэр бүл боловсролын байгууллага, төр, нийгмийн түвшинд идэвхтэй, эрчимтэй ажиллаж байна. Иргэдийн ухамсар болон, эх орны ирээдүй болсон бага насны хүүхдийн хөгжлийг, амьдралын эхний, анхдагч орчноос нь эхлэн сахилга бат суулгах нь хамгийн чухал юм. Өндөр хөгжилтэй орнуудад энэ хариуцлагатай ажил, хүүхдийг эхийн хэвлийд байхаас нь эхэлдэг байна.

Энэ нь жирэмсэн эхийн эмчийн зөвлөгөө, шаардлагаас эхлээд сахилга баттай нүүр тулдаг. Ингэснээр жирэмсэн эх тайван байх, өдрийн дэглэмийн дагуу босох, унтах, амрах, хооллох, салхинд алхах, дасгал хөдөлгөөн хийх, амрах, сувилуулах эрхийг дээд зэргээр хангаж хуульчилж тэр нь яг таг биелэх нь сахилга бат юм. Энэ нь өндөр хөгжил, сайхан амьдрал, иргэдийнхээ аз жаргалыг бүтээж байгаа сахилга хариуцлага юм.

Бага насны хүүхдэд сахилга батын хүмүүжил, төлөвшил суулгахад эцэг эх, асран хамгаалагчид юуг анхаарвал зохилтой вэ?

- Юуны түрүүнд гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг тогтворжуулж хамгаалах;
- Хүүхэдтэйгээ ойр дотно, нөхөрсөг, элгэмсэг харилцааг эрхэмлэх;
- Хүүхдийнхээ хэрэгтэй үед нь хамт байж чаддаг тэдний хамгийн ойр дотны туслагч, зөвлөгч, итгэлтэй түшигтэй хүн байж чадах;
- Хүүхдэдээ хүндэтгэлтэй хандаж, үгийг нь сонсож, уучилж чаддаг байх;

- Гэр бүлийнхээ үнэт зүйл уламжлагдаж ирсэн ёс заншил, зан үйлийн утга учир ач холбогдлыг ойлгуулж мэдүүлэх, өвлүүлэх;
- Гэр бүлийн үнэт зүйлийн нэгэн чухал хэсэг нь гэр орны эмх цэгц, цэвэр цэмцгэр байдал, өдрийн тогтсон дэглэм байдаг. Энэ дэглэмээ эцэг эх, асран хамгаалагч, хүүхэд гэр бүлийн гишүүн бүр ягштал мөрдөж хэвшүүлэх, хүүхдийн насан туршийн дурсамж, амьдралын дүрэм болж төлөвшүүлэх;
- Гэр бүлийн дотор хүүхэд өөрийн гэсэн байр суурьтай, бие даасан гишүүн байх, аливаад өөрийн сонголтоор оролцож юугаар наадах, ямар хувцас өмсөх, юу хийх (зураг зурах, будах, бүтээл хийх) ямар хоол унданд дуртайгаа хэлэх гэх мэт. Хүүхдийн оролцоо идэвх ажлын үр дүн ямар байгааг эцэг эхийн зүгээс хянаж дэмжиж идэвхжүүлж, байнга сэтгэл ханамжийг сайжруулах;
- Гэр бүлийн үнэт зүйлийн нэг нь эрүүл тэжээллэг хоол хүнс хэрэглэх, хоол хүнсээ эрүүл ахуйн сайн нөхцөлд зөв боловсруулж хэрэглэх, тогтоосон хугацаанд зөв хооллох, олдохын хирээр бус өөртөө тохируулж бага багаар зөв идэж хэвших, ил задгай газраас хоол хүнс авч хэрэглэхгүй байх;
- Гэр бүлийн гишүүд хөгжилтэй яриа өрнүүлж, хүүхэд бүр өөрийн үзэж харсан сонирхолтой зүйлээ ярих, сурсан дуу, шүлэг, бүжиг, дасгал, тоглоом, үлгэр ярих үйл ажиллагааны цагтай байж хэвших;
- Гэр бүлийн тогтсон зан заншил, харилцааны соёлыг эрхэмлэж, сайхан мэндлэх, өөр хоорондоо болон ойр орчны танил, найз нөхөд, ах дүүтэйгээ уулзах бүрдээ мэндэлж хэвших, сайн үйл бүтээсний төлөө бие биендээ чин сэтгэлээсээ талархал илэрхийлэх, буруу дутуу үйлдэлдээ уучлал хүсэх, тусламж тусалцаа үзүүлэх мөчид хүүхэдтэйгээ хамт байж үлгэрлэх.

ДҮГНЭЛТ

Энэ бүгдээс үндэслэн авч үзвэл:

- Гэр бүлийн гишүүд дор бүрнээ ажил төрлийн хуваарьтай байж хэвших нь хүүхдийг ажил хөдөлмөрт бие дааж ханддаг, хариуцлага хүлээж сурах суурь хүмүүжил юм. Хүүхдийг ажил хөдөлмөрт оролцоход хамт байж хийх дараалал, эмх цэгцтэй,

цэвэр нямбай, эд юмстай, хямгатай харьцах арга ухааныг биеэрээ үлгэрлэн ажиллавал хүүхэд сэтгэл хангалуун байж ажиллах сонирхол нь нэмэгддэг.

- Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ дэргэд худал ярих, бусдыг муулж ярих, хараах хандлага гаргахгүй байх, улмаар зөвшөөрөлгүйгээр бусдын эд юмсыг авч хэрэглэхгүй байж хэвшинэ.
- Ямар ч нөхцөл байдалд хүүхдийнхээ бие махбодод халдах, сэтгэл санааны дарамт хэрэглэхгүй байх, хүүхдийнхээ нууцыг хадгалж хэвших. Энэ нь ирээдүйн үнэ цэнэтэй иргэн төлөвших суурь хүмүүжил болно.
- Эцэг эх, асран хамгаалагч бүхэн “хүүхэд нэг эрдэнэ, хүмүүжил мянган эрдэнэ” гэсэн зарчмаар ажиллаж үр хүүхдэдээ үнэ цэнэтэй хүмүүжил олгох урт замын аялалдаа хоёргүй сэтгэлээр тууштай хандаж, тэднийг урмаар тэтгэж, чи чадаж байна, сурч байна, илүү сайн болно гэж хийсэн бүтээснийг нь дэмжиж, хийсэн багахан зүйл сурсан дэг журам, эрдмийг нь хүндэтгэн хайрлаж, хадгалж одоо байгааг, урд хийсэн, сурсан зүйлтэй нь харьцуулж өөрөөр нь дүгнүүлж яриулж байвал хүүхэд илүү сайн хөгжинө. Хүүхэд бүр өвөрмөц байдаг учраас бусадтай харьцуулах гэсний хэрэггүй. Хүүхдийн онцлогийг хүлээн зөвшөөрч байх нь чухал. Эцэг эх, асран хамгаалагч бүр хүүхдийнхээ ирээдүй, аз жаргалын төлөө тэдний дотоод сэтгэл, оюуны хөгжил ухамсрын түвшинд, сахилга бат, хувийн зохион байгуулалтад үнэтэй хөрөнгө оруулалт хийж чадаж байгаадаа олзуурхаж, сэтгэл хангалуун байх нь бидний хувьд хамгийн их аз жаргал, бахархал юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Батдэлгэр, Ж. (2002). *Бага насны хүүхдийн сэтгэл зүйн онцлог*. Улаанбаатар
- Боловсрол соёл шинжлэх ухааны яам. (2005). *Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлого*. Улаанбаатар
- Боловсрол соёл шинжлэх ухааны яам. (2009). *Бага насны хүүхдийн хөгжлийн стандартын төсөл*. Улаанбаатар
- Монгол улсын стандарт. (2011). *Сургуулийн өмнөх боловсрол, Бага насны хүүхдийн хөгжил*. Улаанбаатар